

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/208/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АЛБАН БУС НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН  
ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

---

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Төлбөрийн акт .....	14
4.3 Албан шаардлага.....	14
4.4 Зөвлөмж.....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/82  
Танай -ны № -Т

ТӨВ АЙМГИЙН АЛБАН БУС НАСАН  
ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ДУЛАМ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020267

D 2022/2022 ОН/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>311,500.00</u></b>	<b><u>992,597.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	311,500.00	992,597.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	311,500.00	992,597.00
35420	Аж ахуйн материал	291,500.00	972,597.00
35470	Бусад хангамжийн материал	20,000.00	20,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>44,812,567.60</u></b>	<b><u>53,676,402.99</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	44,812,567.60	53,676,402.99
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	44,812,567.60	52,610,014.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	48,000,000.00	48,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,200,000.00	-16,800,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,308,900.00	15,664,770.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-923,459.20	-2,053,032.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,179,000.00	8,817,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-633,799.20	-1,100,649.15
39217	Ном	81,926.00	81,926.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	1,066,388.84
39301	Программ хангамж	00.00	1,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-33,611.16
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>45,124,067.60</u></b>	<b><u>54,668,999.99</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>45,124,067.60</u></b>	<b><u>54,668,999.99</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	45,124,067.60	54,668,999.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	81,926.00	81,926.00
51101	Өмч: - төрийн	81,926.00	81,926.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	45,042,141.60	54,587,073.99
51210	Өмнөх үеийн үр дүн	45,042,141.60	45,042,141.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	9,544,932.39
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>45,124,067.60</u></b>	<b><u>54,668,999.99</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>43,763,500.00</b>	<b>84,301,970.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>43,763,500.00</b>	<b>84,301,970.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	18,993,870.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	18,993,870.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	18,993,870.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	43,763,500.00	65,308,100.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	43,763,500.00	65,308,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>49,341,080.00</b>	<b>74,757,037.61</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>49,341,080.00</b>	<b>74,757,037.61</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	48,917,176.14	65,373,752.48
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	36,979,905.04	46,624,733.89
210101	Үндсэн цалин	35,881,905.04	42,528,010.52
210102	Нэмэгдэл	00.00	2,576,723.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,098,000.00	1,520,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,602,491.10	6,050,373.98
210201	Тэтгэврийн даатгал	3,098,466.89	4,211,937.90
210202	Тэтгэмжийн даатгал	373,046.44	468,439.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	298,436.33	371,391.34
210204	Ажилгүйдлийн даатгал	74,886.55	81,706.76
210205	Эрүүл мэндийн даатгал	757,654.89	916,898.74
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	141,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	141,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,334,780.00	12,557,644.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,757,200.00	1,327,610.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,577,580.00	11,230,034.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	423,903.86	9,383,285.13
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	423,903.86	9,383,285.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	423,903.86	9,383,285.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-5,577,580.00</b>	<b>9,544,932.39</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-5,577,580.00</b>	<b>9,544,932.39</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	81,926.00	00.00	45,042,141.60	<b>45,124,067.60</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>81,926.00</b>	<b>00.00</b>	<b>45,042,141.60</b>	<b>45,124,067.60</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>81,926.00</b>	<b>00.00</b>	<b>45,042,141.60</b>	<b>45,124,067.60</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>81,926.00</b>	<b>00.00</b>	<b>45,042,141.60</b>	<b>45,124,067.60</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,544,932.39	9,544,932.39
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>81,926.00</b>	<b>00.00</b>	<b>54,587,073.99</b>	<b>54,668,999.99</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>43,763,500.00</b>	<b>65,308,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>43,763,500.00</b>	<b>65,308,100.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	43,763,500.00	65,308,100.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	43,763,500.00	65,308,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>43,763,500.00</b>	<b>65,308,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>43,763,500.00</b>	<b>65,308,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>43,339,596.14</b>	<b>55,924,814.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	36,979,905.04	46,624,733.89
210101	Үндсэн цалин	35,881,905.04	42,528,010.52
210102	Нэмэгдэл	00.00	2,576,723.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,098,000.00	1,520,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,602,491.10	6,050,373.98
210201	Тэтгэврийн даатгал	3,098,466.89	4,211,937.90
210202	Тэтгэмжийн даатгал	373,046.44	468,439.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	298,436.33	371,391.34
210204	Ажилгүйдлийн даатгал	74,886.55	81,706.76
210205	Эрүүл мэндийн даатгал	757,654.89	916,898.74
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	361,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	361,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,757,200.00	2,888,707.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,757,200.00	2,888,707.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>423,903.86</b>	<b>9,383,285.13</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	423,903.86	9,383,285.13
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	423,903.86	9,383,285.13
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	65,308,100.00	65,308,100.00	-	100.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	65,308,100.00	65,308,100.00	-	100.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	65,308,100.00	55,924,814.87	9,383,285.13	85.63
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	54,676,800.00	46,624,733.89	8,052,066.11	85.27
210101	Үндсэн цалин	40,417,900.00	42,528,010.52	(2,110,110.52)	105.22
210102	Нэмэгдэл	12,498,900.00	2,576,723.37	9,922,176.63	20.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,760,000.00	1,520,000.00	240,000.00	86.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,381,300.00	6,050,373.98	1,330,926.02	81.97
210201	Тэтгэврийн даатгал	5,194,300.00	4,211,937.90	982,362.10	81.09
210202	Тэтгэмжийн даатгал	546,800.00	468,439.24	78,360.76	85.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	437,400.00	371,391.34	66,008.66	84.91
210204	Ажилгүйдлийн даатгал	109,400.00	81,706.76	27,693.24	74.69
210205	Эрүүл мэндийн даатгал	1,093,400.00	916,898.74	176,501.26	83.86
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	361,000.00	361,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	361,000.00	361,000.00	-	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,889,000.00	2,888,707.00	293.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,889,000.00	2,888,707.00	293.00	99.99
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00	-	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	04.00	04.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	-	-
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дах Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төв нь нийгмийн хөгжлийн чиг хандлага, хувь хүний эрх ашиг, эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсролыг насан туршид нь эзэмшүүлэн, амьдралынх нь чанарыг дээшлүүлэхийг эрхэм зорилгоо болгон насан туршийн боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Насан туршийн боловсрол олгох үйл ажиллагаа
- Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа
- Бичиг үсгийн сургалтын үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төв нь Дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2021 оны батлагдсан төсөвт зардал 65,308.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 979.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 734.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### ***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 65,308.1 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн орлого байхгүй.

#### ***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 13,355.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,638.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,100.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 20,093.9 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,100.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 18,993.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,933.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 1,252.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

#### ***Авлага, өглөгийн талаар:***

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэлгүй. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

### Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 992.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 53,676.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	311.50	992.60	681.10
Үндсэн хөрөнгө	44,812.57	53,676.40	8,863.84
<b>Нийт хөрөнгө</b>	<b>45,124.07</b>	<b>54,669.00</b>	<b>9,544.93</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	45,124.07	54,669.00	9,544.93
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>45,124.07</b>	<b>54,669.00</b>	<b>9,544.93</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 992.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 681.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 53,676.4 мянган төгрөг болж 8,863.8 мянган төгрөгөөр өссөн нь “Хөдөлмөр эрхлэх ур чадварын дээшлүүлэх” төслийн хүрээнд 18,993.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 54,699.0 мянган төгрөг болж 9,544.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 65,308.1 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 65,308.1 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 65,308.1 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 65,308.1 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 55,924.8 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 9,383.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 55,924.8 мянган төгрөг буюу 85.6 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн орлого төвлөрөөгүй.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Бараа материалын дансанд 2014 онд худалдаж авсан байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаггүй 159.5 мянган төгрөгийн зөөврийн хард бүртгэлтэй байна. Энэ нь бараа материалын дансны үлдэгдлийг өсгөж байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлагын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар тушаалаар үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн 2021 оны жилийн тооллого явуулах шийдвэр гаргаж, тооллогыг 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөр тасалбар болгон гүйцэтгэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулан, санхүүгийн тайланд тусган ажилласан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 144 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дах Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвд санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 405.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 140.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 265.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

##### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 140.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд Үндсэн ажлаас гадуур давхар хөдөлмөр эрхэлдэг 1 албан хаагчид ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсоны улмаас нийт 140.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгаж, гарт олгох цалинг илүү олгосон нь: ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ." гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

##### 4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Байгууллагын удирдлагын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн 2021 оны жилийн эцсийн тооллого явуулах шийдвэр гаргаж, тооллогыг 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөр тасалбар болгон гүйцэтгэж, үр дүнг баталгаажуулж, санхүүгийн тайланд тайлагнасан нь: ТБОНӨ-ийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн байгууллагын захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-ээс 31-ний дотор/, 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 220.0 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэж байх

## **2. Зардлын данстай холбоотой асуудал**

### **2.1. Илрүүлэлт:**

Өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй НДШ - ийн 24.2 мянган төгрөгийн өглөг, ХХОАТ-ын 21.6 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд цалингийн зардлаас төлж барагдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүрэн аккурэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэнтэй тус тус нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, НББ-ийг аккурэл сууриар хөтлөх

## **3. Шилэн данстай холбоотой асуудал**

### **3.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд шилэн дансанд 149 мэдээлэл мэдээлэхээс 144 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төв	5	405.8	-	-	1	140.0	1	-	3	265.8

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)